

**ИНВЕСКОР ББСБ ХК-ИЙН 2026 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/				
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.				
Тайлагнах хугацаа	2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр			
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"Инвескор ББСБ" ХК 9010002004 MN00INV05533 77090077			
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж			
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк бус санхүүгийн үйлчилгээ			
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	75,744,281 ширхэг энгийн хувьцаа 2,400,000 ширхэг давуу эрхийн хувьцаа			
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Санхүү Төлөвлөлт, Шинжилгээний Газрын Захирал Б. Бат-Оргил			
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/			
Санхүүгийн байдлын үзүүлэлт	мян.төг	(2026.06.30)	(2025.12.31)	
	Хөрөнгө			
	Бэлэн ба банкин дахь мөнгө	158,582,364	182,148,826	
	Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,102,552,703	882,628,025	
	Санхүүгийн хөрөнгө	1,726,046	22,535,126	
	Урьдчилгаа, бараа материал болон бусад авлага	11,923,951	13,098,054	
	Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	194,989	367,324	
	Өмчлөх бусад болон борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	10,938,140	13,884,917	
	Үндсэн хөрөнгө	18,248,904	18,368,365	

		Биет бус хөрөнгө	6,834,976	6,506,408
		Гүүдвэл	292,627	292,627
		Хойшлогдсон татварын хөрөнгө	512,493	1,091,559
		Нийт хөрөнгө	1,311,807,193	1,140,921,231
		Өр төлбөр		
		Эзлээр авсан санхүүжилт	449,408,809	439,774,354
		Бондын өр төлбөр	148,894,807	115,798,370
		Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	285,127,203	220,332,921
		Бусад санхүүгийн өр төлбөр	29,133,768	19,199,817
		Бусад санхүүгийн бус өр төлбөр	6,198,237	7,828,214
		Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	604,956	355,666
		Орлогын албан татварын өглөг	5,208,972	1,098,856
		Нийт өр төлбөр	924,576,752	804,388,198
		Эздийн өмч		
		Хувьцаат капитал	17,193,952	17,193,952
		Нэмж төлөгдсөн капитал	29,820,733	29,820,733
		Давуу эрхийн хувьцаа	11,831,009	11,831,009
		Халаасны хувьцаа	(5,865,387)	(5,865,387)
		Бусад нөөц	10,253,425	9,169,293
		Хуримтлагдсан ашиг	322,648,950	273,333,404
		Хөрвүүлэлтийн нөөц	941,992	669,743
		Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох эздийн өмч	386,824,674	336,152,747
		Хяналтын бус багц эзэмшигчдэд ногдох	405,767	380,286
		Нийт эздийн өмч	387,230,441	336,533,033
		Нийт өр төлбөр ба эздийн өмч	1,311,807,193	1,140,921,231
Орлогын тайлан		мян.төг	(2026.06.30)	(2025.12.31)
		Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого	182,654,331	310,822,287

		Хүү болон түүнтэй адилтгах зардал	(67,905,034)	(116,879,140)
		Хүүгийн цэвэр орлого	114,749,297	193,943,147
		Хураамж ба шимтгэлийн орлого	22,097,714	40,377,125
		Хураамж ба шимтгэлийн зардал	(421,180)	(583,483)
		Хураамж, шимтгэлийн цэвэр орлого	21,676,534	39,793,642
		Бусад үйл ажиллагааны орлого, цэвэр	5,234,249	6,502,454
		Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулга	(32,889,625)	(59,391,707)
		Үйл ажиллагааны цэвэр орлого	108,770,455	180,847,536
		Хүний нөөцийн зардал	(14,486,407)	(26,735,442)
		Элэгдэл болон хорогдуулгын зардал	(2,453,536)	(4,472,072)
		Удирдлагын зардал	(11,366,070)	(22,667,731)
		Татварын өмнөх ашиг	80,464,442	126,972,291
		Орлогын албан татварын зардал	(17,955,683)	(26,388,496)
		Тайлант жилийн ашиг	62,508,759	100,583,795
Өмчийн тайлан	өөрчлөлтийн	Нэгтгэсэн байдлаар компанийн нийт эздийн өмч 2025.12.31 байдлаар 336.5 тэрбум төгрөг байсан бөгөөд 2026.06.30 байдлаар 387.2 тэрбум төгрөг болж цэвэр дүнгээр 50.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Уг өөрчлөлтийн 62 тэрбум төгрөг нь тайлант хугацааны ашиг, (10.8) тэрбум төгрөг нь зарласан ногдол ашиг байна.		
Мөнгөн тайлан	гүйлгээний	Нэгтгэсэн байдлаар үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (126.4) тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 29.6 тэрбум төгрөг, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 82.8 тэрбум төгрөг байна. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 2025 оны эцсээс 14 тэрбум төгрөгөөр бууран 147.7 тэрбум төгрөг болсон байна.		
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт			
	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 07 сарын 20-ны өдрийн 26/43 дугаар тогтоолоор Компанийн 2026 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг баталгаажуулав.			
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт			

3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	- Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа (8.9% Хангасан) - ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа (15% Хангасан) - ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа (8.8% Хангасан) - Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (12.8% Хангасан) - Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (12.8% Хангасан) - Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (-2.5% Хангасан) - Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (68.1% Хангасан) - Өрийн бичгийн зохистой харьцаа (18.8% Хангасан) - Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа (1.0% Хангасан) *Тусдаа тайлангаар
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (30.1% Хангасан) - Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа (27.1% Хангасан) - Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа (29.4% Хангасан) - Нийт өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа (36.8% Хангасан) *Тусдаа тайлангаар
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	2026 оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлт, уул уурхайн экспорт болон дижитал зээлийн эрэлт ББСБ-ын салбарын өсөлтийг тодорхой хэмжээнд дэмжсэн. Гэсэн хэдий ч өндөр инфляц, шатахууны үнийн өсөлт нь иргэдийн бодит орлого болон зээл төлөх чадварт тодорхой дарамт үзүүлж болзошгүй байна. Мөнгөний хатуу бодлого, өндөр хүү нь ББСБ-ын санхүүжилтийн өртгийг нэмэгдүүлж, ашигт ажиллагаанд тодорхой нөлөө үзүүлсэн байна. Зээлийн багц өссөн ч хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн түвшинд анхаарал хандуулах шаардлага хэвээр байгаа билээ. Хэрэглээний зээлийн шинэ зохицуулалт богино хугацаанд олголтын өсөлтийг сааруулж болох ч урт хугацаанд зээлийн чанарт зөрөг нөлөө үзүүлэх боломжтой гэж үзэж байна. Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаа хувьд өнгөрсөн оны жилийн эцэстэй харьцуулахад нийт 25%-иар өсөж, зээлийн багц 1,103 тэрбум төгрөгт хүрсэн байна.

3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн бүртгэгдсэн гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Инвескор ББСБ ХК-ийн балансын гадуурх ажил гүйлгээний хувьд 2026 оны 6-р сарын 30-ны байдлаар 2.3 их наяд төгрөгийн дүнтэй зээлийн барьцаа хөрөнгө, 17.3 тэрбум төгрөгийн зээлийн шугам, 47.7 тэрбум төгрөгийн тэнцлээс хассан хөрөнгө байгаагаас 24.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сангаар хаасан зээл, 23.5 тэрбум төгрөгийн хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүүгийн авлага, 133.7 сая төгрөгийн авлагын эрсдэлийн сангаар хаасан авлага тус тус байна.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл байгуулаагүй. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ "Инвескор ББСБ" ХК нь Компанийн тухай хууль болон Компанийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам"-ын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эсэх зөвшөөрлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн, сонирхлын зөрчилгүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналаар шийдвэрлэж байна. Тайлант хугацаанд нийт 12 сонирхлын зөрчилтэй хэлцлийг дээрх журмын дагуу байгуулсан байна. Сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь Инвескор Санхүүгийн нэгдлийн оролцогч байгууллагуудтай байгуулсан, олон улсын үнэ шилжилтийн зарчим, харьцуулсан үнийн судалгаанд тулгуурлагдан шийдвэрлэгдсэн бөгөөд үнэт цаас гаргагчийн мэдээлэх үүргийн дагуу нээлттэй мэдээлэгдсэн болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь дээрх зарчим шаардлагуудын дагуу ашиг сонирхлын зөрчлийг зохистойгоор удирдан, хувьцаа эзэмшигчид болон харилцагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан дүгнэлт гарган ажиллаж байна.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд олон нийтэд нээлттэй хэлбэрээр хувьцаа гаргаагүй.
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	Инвескор ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэлтэй, хувьцаа нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг компани юм. Компани нь нийт 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцаатай бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчид нь дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчид, стратегийн болон жижиг хувьцаа эзэмшигчдээс бүрдэж байна. Үүнд: - Эс Ай Би Жэй Капитал ХХК - 80.49% - Олон нийт - 19.51% Компанийн засаглалын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэж, хариуцлагатай, ил тод, нээлттэй үйл ажиллагааг хангах үүднээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг

тогтмол зохион байгуулж, стратегийн ач холбогдол бүхий шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн оролцоотойгоор шийдвэрлэдэг.

Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 гишүүнийг улируулан томилж, шинээр Ш.Эрдэнэбат, Б.Энхмарал нарыг өрдийн гишүүнээр сонгосноор ТУЗ нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгогдсон, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томилоход гишүүдийн мэргэжлийн туршлага, хараат бус байдал, олон талт байдлыг хангах зарчмуудыг харгалзан үзсэн бөгөөд уг үйл явцад ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд үнэлгээ, дүгнэлт хийж Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулж шийдвэрлүүлсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд:

- Д.Энхбат
- Ч.Хашчулуун
- Ч.Өнөржаргал

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд:

- Д.Баясгалан
- Б.Анхболд
- Ш.Эрдэнэбат
- Х.Намики (Япон улсын иргэн)
- Р.Пүрэв
- Б.Энхмарал

Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 төрлийн тодорхой асуудал эрхэлсэн байнгын хороодтой. Байнгын хороодын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд томилогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод:

1. **Аудитын хороо:** Дарга - Ч. Хашчулуун; Гишүүд – Ч.Өнөржаргал, Р. Пүрэв
2. **Цалин урамшууллын хороо:** Дарга - Д. Энхбат; Гишүүд - Ш. Эрдэнэбат, Ч. Өнөржаргал
3. **Нэр дэвшүүлэх хороо:** Дарга - Ч. Хашчулуун; Гишүүд - Д. Энхбат, Х. Намики
4. **Эрсдэлийн удирдлагын хороо:** Дарга - Ч. Өнөржаргал; Б. Анхболд, Ч. Хашчулуун
5. **Тогтвортой байдлын хороо:** Дарга - Д. Энхбат; Д. Баясгалан, Б. Энхмарал

Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааны мэдээлэл:

Д. Баясгалан	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Тогтвортой байдлын хорооны гишүүн	0.0042%
Р. Пүрэв	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Аудитын хорооны гишүүн	0.0070%
Б. Анхболд	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн	0.0355%
Ш. Эрдэнэбат	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Цалин урамшууллын хорооны гишүүн	1.8892%
Хирохито Намики	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	0
Б. Энхмарал	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Тогтвортой байдлын хорооны гишүүн	0.0055%

Ч. Хашчугуун	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	0
Д. Энхбат	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Цалин урамшууллын хорооны дарга, Тогтвортой байдлын хорооны дарга	0
Ч. Өнөржаргал	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Аудитын хорооны гишүүн, Цалин урамшууллын хорооны гишүүн	0

Удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

Тайлант хугацаанд буюу 2026 оны 01 сарын 28-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 26/05 дугаар шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Анхболдыг чөлөөлж, мөн өдрийн 26/07 дугаар шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Баясгаланг томилсон.

Д.Баясгалан нь Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаал эрхэлж байсан бөгөөд 2026 оны 01 сарын 28-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 26/06 дугаар шийдвэрээр Гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлөгдөж, Д.Оролмааг Гүйцэтгэх захирлаар томилов. Энэхүү удирдлагын багийн өөрчлөлт нь компанийн засаглалыг дараагийн түвшинд гаргах менежментийн өөрчлөлт, шинэчлэлт хийх зорилготой бөгөөд олон нийтэд нээлттэй мэдээлэн, шинэчилсэн бүрэлдэхүүнээр 2026 оны эхний хагас жилийг амжилттай дуусгаж байна.

6. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

Компанийн засаглалын үнэлгээг Монгол Улсын Компанийн тухай хууль, СЗХ-ноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан компанийн засаглалын зарчмуудын дагуу жил бүр үнэлэн, Санхүүгийн зохицуулах хороогоор хянан баталгаажуулж, олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллаж байна.

"Инвекор ББСБ" ХК-ийн Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг 2025 оны жилийн эцсийн байдлаар СЗХ хянан баталгаажуулж 93.1 хувь буюу засаглал сайн, эрсдэлгүй гэж үнэлсэн.

Компани нь жил бүр болон давтан үнэлгээний тайлангаар компанийн засаглалын чанар, хяналт, удирдлагын тогтолцоог илүү үр дүнтэй хэрэгжүүлэх харилцагч болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр тасралтгүй анхааран ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д. Оролмаа
Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



InvesCore FI



2026

Оны эхний хагас

Санхүү, үйл ажиллагааны
тайлан

Агуулга

- 1 Онцлох үйл явдал
- 2 Бизнесийн үйл ажиллагаа
- 3 Санхүүгийн үр дүн
- 4 Эрсдэлийн удирдлага
- 5 Тогтвортой хөгжил
- 6 Компанийн засаглал

01. 2026 оны онцлох үйл явдлууд

Онцлох үйл явдлууд


Шинэ салбар



10 жилийн ой

Инвескор БСББ ХК нь 16.7 их наяд төгрөгийн бизнесийн зээлийг 13,000 гаруй бизнес эрхлэгчдэд олгож улсын төсөвт 137.1 тэрбум төгрөгийн татвар бүрдүүлсэн 10 жилийн ойг тэмдэглэв.

Онцлох үйл явдлууд



Топ 100 аж ахуйн нэгжээр дахин шалгарлаа

Инвескор ББСБ ХК нь Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас хамтран шалгаруулдаг "ТОП-100 аж ахуйн нэгж"-ийн нэгээр хоёр дахь жилдээ дахин тодорлоо.



Core Synergy VIP event

Компанийн стратегийн харилцагчид болон хамтран ажилладаг түншүүдтэйгээ хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ боломжуудыг нээх зорилготой Core Synergy VIP цуврал нетворкинг арга хэмжээг дахин зохион байгууллаа.

Ногоон өсөлт хөнгөлөлттэй зээл

Тогтвортой санхүүжилтийг дэмжих бодлогын хүрээнд Тогтвортой санхүүжилтийн холбоотой хамтран "Бичил, жижиг, дунд эмэгтэй бизнес эрхлэгч"-д зориулсан батлан даалттай Ногоон өсөлт зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлээ. Уг хөтөлбөрт ББСБ-ыг төлөөлөн оролцох болсон нь хүртээмжтэй, тогтвортой санхүүжилтийг дэмжихэд чухал алхам боллоо.



Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл болон бусад шинэ бүтээгдэхүүнүүд

Эдийн засгийн салбаруудын онцлогт тохируулан Ногоон өсөлт хөнгөлөлттэй зээл, Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл, Тендерийн гэрээ барьцаалсан зээл, Оюуны емч барьцаалсан зээл, Тавилгын зээл зэрэг олон төрлийн бүтээгдэхүүнийг харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан нэвтрүүлээд байна.

Онцлох үйл явдлууд

Zero Marathon-2026

BNPL үйлчилгээг сурталчлан таниулах зорилготойгоор жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг арга хэмжээг энэ удаад бүтэн жилийг хамарсан урт хугацааны байдлаар Zero Marathon концепцийн хүрээнд зохион байгуулж байна.



Asia Fintech Awards-2026

Азийн финтек байгууллагуудыг тогтвортой хөгжил, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, инновац, манлайлал зэрэг гол үзүүлэлтээр үнэлдэг Asia Fintech Awards 2026-ийн 3 төрөлд финалистаар шалгарлаа.

- LendTech of the Year
- Director of the Year
- Best ESG Campaign



ТОП-300 ААН

Покет ББСБ ХХК нь Засгийн газар, МҮХАҮТ-с уламжлал ёсоор жил бүр шалгаруулдаг Монгол Улсын ТОП-300 аж ахуйн нэгжийн жагсаалтын 165 дугаарт эрэмбэлэгдэв.



02. Бизнесийн үйл ажиллагаа

Төв Ази дахь үйл ажиллагаа - Киргиз Улс

Инвескор СА




Инвескор СА компанийн цэвэр зээлийн багц 78 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс **20.2%**-иар өссөн байна. Онлайн бичил зээлийн дижитал бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлж, үйлчилгээний сүлжээгээ өргөжүүлэн Манас хотод шинэ салбараа, Ош хотод хоёр дахь салбараа тус тус нээлээ. Эдгээр амжилтын үр дүнд 2026 оны байдлаар Киргиз улсын банк бус санхүүгийн байгууллагуудын зах зээлд 5 дугаар байраа дахин бататгалаа.

2025 оны 11 сард Тажикистан улсад зохион байгуулагдсан "Central Asia Microfinance Summit 2025" чуулганы үеэр "Бичил санхүүгийн салбарын хөгжил болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд оруулсан онцгой хувь нэмэр" шагналыг хүртлээ.



Дотоодын болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас нийт 6.0 сая ам.долларын санхүүжилт амжилттай татан төвлөрүүлэн, үүнээс Узбек-Киргизийн Хөгжлийн Сан-тай 1.0 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ байгууллаа.




Цэвэр зээлийн Багц:
Салбарын тоо:

78 тэрбум ₮
7



Цэвэр зээлийн багц
тэрбум төгрөг



Төв Ази дахь үйл ажиллагаа - Казахстан Улс

Инвескор Финанс




Инвескор Финанс компанийн цэвэр зээлийн багц 28 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс **9.2%**-иар өссөн байна. Казахстаны 212 банк бус санхүүгийн байгууллагаас 42 дугаарт эрэмбэлэгдэн, зах зээл дэх байр сууриа тогтмол ахиулсаар байна.

2026 онд Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, компанийн засаглалыг сайжруулан, стратегийн хяналт, удирдлагыг улам бэхжүүллээ. Мөн компанийн вэбсайтыг бүрэн шинэчилж, хэрэглэгчийн туршлагыг (UX) сайжруулахын зэрэгцээ бүтээгдэхүүний мэдээлэл, харилцагчдад чиглэсэн контентыг өргөжүүлэн, мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, санхүүгийн боловсролыг дэмжих боломжийг бүрдүүллээ.



TrustMe

Түүнчлэн, TrustMe платформ (trustme.kz)-ийг нэвтрүүлснээр зээлийн гэрээний үйл явцыг бүрэн цахимжуулж, цахимаар гарын үсэг зурах боломжийг бүрдүүллээ. Үүний үр дүнд харилцагчид хэдхэн минутын дотор гэрээгээ хянаж, баталгаажуулах боломжтой болж, зээлийн боловсруулалтын хугацаа богиносж, үйл ажиллагааны үр ашиг болон хэрэглэгчийн туршлага сайжирлаа.




Алматы

Цэвэр Зээлийн Багц:
Салбарын тоо:

28 тэрбум ₸
1




Цэвэр зээлийн багц
тэрбум төгрөг




03. Санхүүгийн үр дүн

Санхүүгийн үр дүн (Нэгтгэсэн)


Нийт актив
(тэрбум төгрөг)




Цэвэр зээлийн багц
(тэрбум төгрөг)



Хүү шимтгэлийн орлого
(тэрбум төгрөг)



Цэвэр ашиг
(тэрбум төгрөг)




*Аудитлагдаагүй


Зохистой харьцаа үзүүлэлт	Босго	2026 H1	Төлөв
Өөрийн хөрөнгө, Эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>20%	29.4%	Хангасан
Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа	>8%	30.1%	Хангасан
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	<80%	68.1%	Хангасан
Бондын харьцаа	<30%	18.8%	Хангасан

Санхүүгийн үр дүн (Нэгтгэсэн)


Хөшүүрэг




Зээл активын харьцаа



Чанаргүй зээлийн харьцаа




Өөрийн хөрөнгийн өгөөж




* Жилийн сууриар

Активын өгөөж



Хувьцааны ханшийн гүйцэтгэл



2026 оны 6-р сарын 30 байдлаар

Зах зээлийн үнэлгээ	673.7 тэрбум ₮
Хаалтын ханш	8,895 ₮
Ханшийн хэлбэлзэл (жилийн)	-4.8%
Ханшийн хэлбэлзэл (оны эхнээс)	-1.2%

04. Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага

Инвекор ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагчид болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, компанийн урт хугацааны тогтвортой өсөлт, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэн ажилладаг. Компанийн эрсдэлийн удирдлага нь бизнесийн ёс зүй, сайн засаглал, ил тод байдал болон хариуцлагын зарчимд тулгуурлан, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого, холбогдох журам, аргачлалын хүрээнд хэрэгждэг.

Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны үндсэн зорилго нь бизнесийн стратеги, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлагыг бүрэн хангах, үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй эрсдэлийг цаг тухайд нь илрүүлж, үнэлэх, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд оновчтой удирдах, улмаар компанийн хөрөнгө, нэр хүнд, санхүүгийн тогтвортой байдал болон бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хамгаалахад чиглэгддэг.

Хамгаалалтын 3 бүс

Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлах бөгөөд бүх нэгж өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, тайлагнах чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд компани нь эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо доорх хамгаалалтын гурван шугамын зарчимд нийцүүлэн хэрэгжүүлж, эрсдэлийн үнэлгээ, мониторинг, тайлагнал болон дотоод хяналтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан ажиллав.

Хамгаалалтын I бүс - Бизнесийн болон дэмжих нэгжүүд

Өдөр тутмын үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлийг таньж илрүүлэх, бууруулах арга хэмжээг шууд хэрэгжүүлэх учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, бууруулах, хянах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

Хамгаалалтын II бүс - Хууль, эрсдэл, комплаенсийн газар

Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, аргачлалыг боловсруулж, эрсдэлийн үнэлгээ, мониторинг, тайлагнал болон дотоод хяналтын хэрэгжилтэд хараат бус хяналт тавьж, бизнесийн нэгжүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

Хамгаалалтын III бүс - Дотоод аудитын газар

Эрсдэлийн удирдлага болон засаглалын тогтолцооны үр нөлөөг хараат бусаар үнэлж, сайжруулах зөвлөмж гарган, хэрэгжилтэд хяналт тавих ба ТУЗ-д хараат бусаар тайлагнана.



Эрсдэлийн соёл

Эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх нь компанийн засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Инвекор ББСБ ХК-д эрсдэлийн удирдлага нь зөвхөн тусгайлсан нэгжийн бус, байгууллагын бүх түвшний ажилтан, удирдлагын хамтын оролцоо, хариуцлагад тулгуурлах зарчмыг баримталдаг. Ажилтан бүр өөрийн чиг үүргийн хүрээнд эрсдэлийг тухай бүр таньж илрүүлэх, үнэлэх, мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд удирдахад хувь нэмэр оруулах үүрэгтэй.

Энэхүү хандлагыг дэмжих, эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх зорилгоор тайлант хугацаанд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн процесс болон бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд Эрсдэл ба хяналтын өөрийн үнэлгээ (Risk and Control Self-Assessment – RCSA)-г тогтмол хэрэгжүүлж, болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлон, үнэлж, шаардлагатай хяналтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэв.

Мөн эрсдэлийн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх дотоод тогтолцоог хөгжүүлж, бүртгэгдсэн тохиолдлуудад дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах механизмыг бүрдүүлсэн. Ажилтнуудын эрсдэлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор тохиолдлын мэдээллийн нууцлалыг ханган, кейс хэлбэрээр тогтмол түгээж, байгууллагын хэмжээнд эрсдэлийг шуурхай мэдээлэх, эрсдэлийн талаарх хариуцлагатай хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр ажиллав.

Голлох эрсдэлүүд



Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь компанийн үндсэн эрсдэл бөгөөд зээлдэгчийн төлбөрийн чадвар, зээлийн багцын чанар, төвлөрлийн эрсдэлийг тогтмол үнэлж, хяналт тавин ажилладаг билээ. Тайлант хугацаанд зээлийн багцын төвлөрлийг бууруулах, барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч, зээлийн шинжилгээ, скорингийн загварыг сайжруулах ажлыг тасралтгүй хийж, зээл олгох шатны шинжилгээний аргачлалыг шинэчилсэн. Мөн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг бууруулах зорилгоор дэмжих нэгжийн ажилтнууд нь бизнесийн нэгжүүдэд тогтмол дэмжлэг үзүүлэн ажиллаж нийт зээлийн багц дахь чанаргүй зээлийн эзлэх хувийг нэмэгдүүлэхгүйгээр хяналтдаа байлган зээлийн эрсдэлийг удирдан ажиллав.



Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл нь хүний хүчин зүйл, дотоод процесс, мэдээллийн системийн доголдол болон гаднын үйл явдлын улмаас санхүүгийн алдагдал, үйл ажиллагааны тасалдал үүсэх эрсдэл юм. Компани нь үйл ажиллагааны эрсдэлийг Эрсдэл ба хяналтын өөрийн үнэлгээ (RCSA), эрсдэлийн тохиолдлын бүртгэл, дотоод хяналтын тогтолцоо болон бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөгөөр дамжуулан удирддаг. Мөн ажилтнуудын эрсдэлийн талаарх мэдлэг, эрсдэлийн соёлыг бэхжүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэв.



Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэл

Тайлант хугацаанд компани нь зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх хэмжээнд хангаж ажиллахын зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажиллав. Макро эдийн засгийн төлөв байдал, гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөллийг хөндлөнгийн судалгааны байгууллагын шинжилгээ болон дотоод үнэлгээнд үндэслэн тогтмол үнэлж, гадаад валютын нээлттэй позицийн хяналтыг хэрэгжүүлэн, үр дүнг бизнесийн болон санхүүгийн шийдвэр гаргалтад ашиглав.

Мөн хөрвөх чадварын тогтвортой байдлыг хангах, санхүүжилтийн төвлөрлийн эрсдэлийг бууруулах зорилгоор эх үүсвэрээ олон улсын банк, санхүүгийн байгууллага, дотоодын хөрөнгийн зах зээлд гаргасан нээлттэй болон хаалттай бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ) зэрэг төрөл бүрийн санхүүжилтийн хэрэгслээр төрөлжүүлэн бүрдүүлж, урт хугацааны тогтвортой санхүүжилтийн бүтцийг хадгалан ажиллав.



Хууль эрх зүй, комплаенсийн эрсдэл

Компани нь хууль, эрх зүй, комплаенсийн эрсдэлийг үр дүнтэй удирдах зорилгоор хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын эрх зүйн актын шинэчлэл, өөрчлөлтийг тогтмол хянан шинжилж, холбогдох нэгж, удирдлагад тухай бүр мэдээлэн хэрэгжилтийг ханган ажиллав. Тайлант хугацаанд дотоод аргачлалын дагуу хуулийн нийцлийн үнэлгээг хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн дотоод бодлого, журамд шаардлагатай өөрчлөлтийг тусган шинэчилсэн. Мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажилтнуудын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, хууль тогтоомжид заасан тайлан, мэдээллийг эрх бүхий байгууллагад хугацаанд нь хүргүүлэн ажиллав.

Мэдээллийн аюулгүй байдал



Мэдээллийн аюулгүй байдлын засаглал

Инвескор ББСБ ХК нь тайлант хугацаандаа Мэдээллийн аюулгүй байдлын бодлогоо шинэчлэн боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулснаар мэдээллийн аюулгүй байдал болон кибер аюулгүй байдлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх удирдлагын бодлого, зарчим, чиглэлийг тодорхой болголоо.

Цаашид байгууллага нь олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоогоо тасралтгүй сайжруулж, шинээр үүсэж буй кибер аюул заналд хариу үйлдэл үзүүлэх болон тэсвэрлэх чадавхаа нэмэгдүүлж, бизнесийн тасралтгүй ажиллагааг хангах чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.



Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхдээ ISO/IEC 27001:2022 олон улсын стандарт болон "Хамгаалалтын гурван шугам"-ын зарчимд үндэслэн ажилладаг бөгөөд 5 дах жилдээ хөндлөнгийн аудитын байгууллагаар амжилттай баталгаажуулж байна.

Энэхүү баталгаажуулалт нь компанийн үндсэн үйл ажиллагаа, систем болон аппликейшнийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн процессууд нь мэдээллийн аюулгүй байдлын олон улсын шаардлагад бүрэн нийцсэн бөгөөд байгууллага болон харилцагчдын мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг хангаж буйг баталгаажуулж байна.



Мэдээлэл технологийн эрсдэлийн удирдлага

ББСБ нь мэдээллийн технологийн эрсдэлийг тогтмол тодорхойлж, үнэлэн, бууруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлдэг. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд "defence-in-depth" буюу давхарласан хамгаалалтын зарчмыг хүн, процесс, технологийн түвшинд хэрэгжүүлж, дэлхийн тэргүүлэх технологийн шийдэл, эмзэг байдлын удирдлага, логийн төвлөрсөн хяналтын системийг ашиглан кибер халдлага болон мэдээлэл алдагдах эрсдэлийг бууруулан ажиллаж байна.



InvesCore FI × 

Түүнчлэн кибер аюулгүй байдлын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын "Цахим аюулгүй байдлын мэдээлэл удирдлагын төв" (MN CERT/CC)-ийн гишүүн байгууллага болж, шинээр үүсэж буй кибер аюул заналын мэдээллийг шуурхай хүлээн авах, үндэсний хэмжээний хамтын ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүллээ.

05. Тогтвортой хөгжил

Тогтвортой хөгжил

2026 оны эхний хагас жилд Инвескор ББСБ ХК нь байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)-ын чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх, ногоон санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ.




2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангаа олон нийтэд танилцуулж, тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгээ нэгтгэн хүргэлээ.



ESG Club-ийн хүрээнд "Өнгө Нэм" ТББ-тай хамтран ажилтнуудад хог хаягдлын менежментийн сургалт зохион байгуулж, "Түмэн Эгшиг" ХХК-тай хамтран нийт 314 кг цахим хог хаягдлыг дахин боловсруулах болон зориулалтын дагуу устгахад шилжүүллээ.

InvesCore FI × ToC

ToC Холбооны хэрэгжүүлж буй RFF хөтөлбөрийн грантын хүрээнд хэрэгжих Ногоон батлан даалтын тогтолцооны төсөлд нэгдэн, "Ногоон өсөлт хөнгөлөлттэй зээл"-ийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэн эмэгтэй болон ногоон бизнес эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.



InvesCore FI × PCAF Partnership for Carbon Accounting Financials

2023 онд нэгдсэн Partnership for Carbon Accounting Financials (PCAF) буюу "Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн сайн дурын түншлэл"-ийн хүрээнд санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлаа олон улсын аргачлалын дагуу анх удаа тооцоолж, тайлагналаа.



Ногоон бизнес эрхлэгчдэд зориулсан "Core Synergy: Green Growth" арга хэмжээг зохион байгуулж, 25 байгууллагын 33 төлөөллийг хамруулан тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн талаарх мэдлэгийг түгээж, салбарын хамтын ажиллагааг өргөжүүллээ.

06. Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөл

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 гишүүнийг улируулан томилж, шинээр 2 гишүүнийг сонгосноор ТУЗ нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгогдсон.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томилоход гишүүдийн мэргэжлийн туршлага, хараат бус байдал, олон талт байдлыг хангах зарчмуудыг харгалзан үзсэн бөгөөд уг үйл явцад ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд үнэлгээ, дүгнэлт хийж Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулсан болно.



Д. Баясгалан

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Б. Анхболд

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн



Хирохито Намики

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн



Р. Пүрэв

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн



Ш. Эрдэнэбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн



Б. Энхмарал

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн



Ч. Хашчулуун

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн



Ч. Өнөржаргал

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн



Д. Энхбат


Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Компанийн засаглалын хүрээнд тайлант хугацаанд Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь компанийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор холбогдох дүрэм, журам, бодлогыг мөрдөж ажилласан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекс-т нийцүүлэн бүрдүүлсэн.

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу Компани нь 5 төрлийн байнгын хороодыг байгуулан, хороо бүр гуравны хоёроос доошгүй төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 25/30 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсан.



Хороодын гишүүд

	Дарга	Гишүүд
Аудитын хороо	Ч. Хашчулуун	Ч. Өнөржаргал, Р. Пүрэв
Цалин урамшууллын хороо	Д. Энхбат	Ш. Эрдэнэбат, Ч. Өнөржаргал
Нэр дэвшүүлэх хороо	Ч. Хашчулуун	Д. Энхбат, Х. Намики
Эрсдэлийн удирдлагын хороо	Ч. Өнөржаргал	Б. Анхболд, Ч. Хашчулуун
Тогтвортой байдлын хороо	Д. Энхбат	Д. Баясгалан, Б. Энхмарал

Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур

Бизнес төлөвлөгөөнд тусгасан Тэнцвэржүүлсэн онооны систем дэх зорилтуудын биелэлтээр Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин болон бусад урамшууллыг олгодог. Үүнд доорх 4 үндсэн бүлэг үзүүлэлтүүдийг багтаана.



Санхүүгийн тоон зорилтуудын биелэлт



Дотоод процессын сайжруулалт, бизнес хөгжлийн үйл ажиллагааны зорилтуудын биелэлт



Зах зээл, бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчийн үйлчилгээний зорилтуудын биелэлт



Хүний нөөц, бүтээмжтэй холбоотой зорилтуудын биелэлт

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон хувьцаа эзэмшигчдийн оролцоо

Инвекор ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэлтэй, хувьцаа нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг компани юм. Компани нь нийт 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцаатай бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчид нь дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчид, стратегийн болон жижиг хувьцаа эзэмшигчдээс бүрдэж байна. Үүнд:

- **Эс Ай Би Жэй Капитал ХХК** **80.49%**
- **Олон нийт** **19.51%**

Компанийн засаглалын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэж, хариуцлагатай, ил тод, нээлттэй үйл ажиллагааг хангах үүднээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тогтмол зохион байгуулж, стратегийн ач холбогдол бүхий шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн оролцоотойгоор шийдвэрлэдэг.



Инвекор ББСБ ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал танхимаар компанийн төв оффисын байранд буюу Ай Си Тауэр барилгад, инвекор аппликейшн, вэб хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр 2026 оны 4-р сарын 29-ний өдөр хуралдаж, амжилттай өндөрлөсөн.

Хуралд нийт саналын эрх бүхий нийт хувьцаа эзэмшигчдийн 87.41 хувь нь оролцож, хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.98 хувийн саналаар Компанийн 2025 оны үйл ажиллагааны санхүүгийн тайланг батлах, ТУЗ-ийн төсөв батлах, Компанийн хувьцааг хувааж, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн батлав.

Компанийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх санаачилгуудыг тууштай хэрэгжүүлж, уламжлал ёсоор хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд модны үрсэлгээ бэлэглэж, энэ жил 100 хайлаас мод тарих боломжийг бүрдүүллээ.


Энэхүү санаачилга нь жилд ойролцоогоор 2–3 тонн хүчилтөрөгчийг байгальд бий болгохоос гадна агаарын бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгахад бодит хувь нэмэр оруулах юм.

Дотоод аудитын үйл ажиллагаа

Дотоод аудитын үйл ажиллагаа нь эрсдэлд суурилсан аргачлалаар, хараат бус, бодитой баталгаажуулалт хийх болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэн нэмэх, стратегийн зорилгод хүрэхэд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг.

Инвескор ББСБ ХК-ийн Дотоод аудитын газар нь чиг үүргийн болон захиргааны хувьд Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), Аудитын хороонд харъяалагдаж, гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг. Дотоод аудитын газар нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд ажлынхаа талаар тайлагнаж, аудитын үр дүнг гүйцэтгэх удирдлагад мэдээлэх зарчмаар ажилладаг.

Дотоод аудитын бүтэц



Аудитын хороо нь дотоод аудитын жилийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийг хэлэлцэн батлах, дотоод аудитын үйл ажиллагаа болон хараат бус байдалд хяналт тавихын зэрэгцээ аудитын үйл ажиллагааг дэмжин ажилладаг.

2026 оны хагас жилд үйл ажиллагааны, нийцлийн болон тусгай аудитуудыг гүйцэтгэж, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны баталсан төлөвлөгөөг биелүүлсэн байна.

Дотоод аудитыг сурталчилах сарын хүрээнд удирдах түвшний ажилтнуудад зориулан "Эрсдэл, хяналт болон дотоод аудит" сэдвээр танхимын сургалт, нийт ажилтнуудад "Дотоод, гадаад залилангаас хэрхэн сэргийлэх", "Шүгэл үлээхийн ач холбогдол" болон "Эрсдэлд суурилсан дотоод хяналт" сэдвүүдээр видео сургалтууд боловсруулж, нийт ажилтнуудад нээлттэй байршуулсан.



Дотоод аудитын газар нь Олон улсын дотоод аудиторуудын институти (IIA)-ийн боловсруулсан Олон улсын дотоод аудитын стандарт, сайн засаглалын зарчмууд, шилдэг туршлагыг аудитын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

InvesCore FI | 10

+976 7709-0077
info@invescore.mn
www.invescore.mn